

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/138/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/175
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.МАРТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 сс/АНДЫН ВИСНИГ
19020538

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,425,278.44	69,160,535.44
35	БАРАА МАТЕРИАЛ	46,425,278.44	69,160,535.44
351	Түүхий эд материал	910,600.00	1,891,500.00
35110	Тусгай зориулалттай материал	910,600.00	910,600.00
35130	Эм боох материал	00.00	980,900.00
354	Хангамжийн материал	45,514,678.44	67,269,035.44
35410	Бичиг хэргийн материал	795,072.00	733,262.00
35420	Аж ахуйн материал	4,792,385.00	6,995,595.00
35460	Хүнсний материал	00.00	1,150,130.00
35470	Бусад хангамжийн материал	39,927,221.44	58,390,048.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,207,428,105.01	1,156,405,023.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,207,428,105.01	1,156,405,023.54
392	Биет хөрөнгө	1,158,318,105.01	1,107,295,023.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,180,114,409.97	1,180,114,409.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	-54,681,624.56	-100,241,872.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,529,417.00	61,351,263.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,739,283.82	-41,135,674.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,468,327.36	30,424,827.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,433,140.94	-23,920,229.80
39217	Ном	60,000.00	702,300.00
393	Биет бус хөрөнгө	49,110,000.00	49,110,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	49,110,000.00	49,110,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,253,853,383.45	1,225,565,558.98
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,253,853,383.45	1,225,565,558.98
51	Засгийн газрын хувь оролцоо	1,253,853,383.45	1,225,565,558.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	245,410,654.36	245,410,654.36
51101	Өмч: - төрийн	245,410,654.36	245,410,654.36
512	Хуримтлагдсан үр дүн	935,134,586.75	906,846,762.28
51210	Өмнөх үеийн үр дүн	935,134,586.75	935,134,586.75
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-28,287,824.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	73,308,142.34	73,308,142.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,253,853,383.45	1,225,565,558.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,749,776,698.00	647,950,260.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,106,819,653.00	21,306,960.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,106,819,653.00	21,306,960.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,106,819,653.00	21,306,960.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,106,819,653.00	21,306,960.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,815,145.00	89,416,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	571,141,900.00	537,227,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,650,745.00	17,607,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,954,500.00	17,507,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,696,245.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,164,400.00	71,808,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,164,400.00	71,808,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	690,748,792.05	676,238,084.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	690,748,792.05	676,238,084.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	583,205,266.24	581,416,033.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	388,428,152.60	390,911,118.36
210101	Үндсэн цалин	256,757,919.03	253,742,092.32
210102	Нэмэгдэл	89,294,560.26	91,545,393.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,300,000.00	12,770,145.62
210104	Урамшуулал	31,075,673.31	32,853,487.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,304,456.59	51,486,613.43
210201	Тэтгэврийн даатгал	36,804,656.51	36,542,401.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,821,067.60	3,884,002.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,978,344.06	3,106,609.49
210204	Ажилгүйдлийн даатгал	436,327.72	768,043.68
210205	Эрүүл мэндийн даатгал	5,264,060.70	7,185,556.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,578,955.00	61,972,122.00
210301	Гэрэл, цахилгаан	3,947,575.00	3,263,822.00
210302	Түлш, халаалт	54,631,380.00	58,708,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,339,569.92	3,008,923.00
210401	Бичиг хэрэг	951,150.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	240,600.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,000.00	170,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	84,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	323,000.00	533,850.00
210408	Бараа материал акталсны зардал	761,819.92	1,620,773.00

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	36,878,214.00	17,469,955.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	70,000.00
210502	Хоол, хүнс	35,118,010.00	15,910,465.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,760,204.00	1,489,490.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,170,745.00	500,000.00
210604	Урсгал засвар	4,170,745.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	60,000.00	132,500.00
210702	Дотоод албан томилолт	60,000.00	132,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,725,173.13	55,934,801.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	261,400.00	1,047,310.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	558,300.00	1,722,110.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,905,473.13	53,165,381.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,543,525.81	94,822,051.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,954,500.00	17,507,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	12,554,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,954,500.00	4,953,100.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	102,589,025.81	77,314,351.21
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	102,589,025.81	77,314,351.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,059,027,905.95	-28,287,824.47
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	32,113.64	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	32,113.64	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-32,113.64	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,058,995,792.31	-28,287,824.47

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,300,654.36	3,376,518.00	-74,369,030.97	125,308,141.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,300,654.36	3,376,518.00	-74,369,030.97	125,308,141.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,249,516.96	-10,249,516.96
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,410,654.36	73,308,142.34	935,134,586.75	1,253,853,383.45
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,410,654.36	73,308,142.34	935,134,586.75	1,253,853,383.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,410,654.36	73,308,142.34	935,134,586.75	1,253,853,383.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-28,287,824.47	-28,287,824.47
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,410,654.36	73,308,142.34	906,846,762.28	1,225,565,558.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	642,957,045.00	626,643,300.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	642,957,045.00	626,643,300.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	571,141,900.00	537,227,300.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,650,745.00	17,607,700.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	100,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,954,500.00	17,507,700.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,696,245.00	00.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,164,400.00	71,808,300.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,164,400.00	71,808,300.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	642,957,045.00	625,851,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	642,957,045.00	625,851,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	535,413,519.19	530,928,948.79	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	388,428,152.60	390,911,118.36	
210101	Үндсэн цалин	256,757,919.03	253,742,092.32	
210102	Нэмэгдэл	89,294,560.26	91,545,393.29	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,300,000.00	12,770,145.62	
210104	Урамшуулал	31,075,673.31	32,853,487.13	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,304,456.59	51,486,613.43	
210201	Тэтгэврийн даатгал	36,804,656.51	36,542,401.56	
210202	Тэтгэмжийн даатгал	3,821,067.60	3,884,002.66	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,978,344.06	3,106,609.49	
210204	Ажилгүйдлийн даатгал	436,327.72	768,043.68	
210205	Эрүүл мэндийн даатгал	5,264,060.70	7,185,556.04	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,578,955.00	61,972,122.00	
210301	Гэрэл, цахилгаан	3,947,575.00	3,263,822.00	
210302	Түлш, халаалт	54,631,380.00	58,708,300.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	1,734,700.00	2,402,000.00	
210401	Бичиг хэрэг	80,000.00	100,000.00	
210402	Тээвэр, шатахуун	160,000.00	200,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,000.00	170,000.00	
210404	Ном, хэвлэл	84,300.00	84,300.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	300,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,347,400.00	1,547,700.00	
2105	Нормативт зардал	30,236,710.00	18,630,595.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,000.00	70,000.00	
210502	Хоол, хүнс	29,751,710.00	17,060,595.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	1,500,000.00	

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,196,245.00	500,000.00
210604	Урсгал засвар	3,196,245.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	60,000.00	132,500.00
210702	Дотоод албан томилолт	60,000.00	132,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,154,300.00	4,894,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,720,000.00	3,172,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,434,300.00	1,722,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,543,525.81	94,922,051.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,954,500.00	17,607,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	12,554,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,954,500.00	4,953,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	100,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	102,589,025.81	77,314,351.21
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	102,589,025.81	77,314,351.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	792,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	792,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	792,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	792,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	792,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-792,300.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	609,035,600.00	531,721,248.79	77,314,351.21	87.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	609,035,600.00	531,721,248.79	77,314,351.21	87.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	609,035,600.00	531,721,248.79	77,314,351.21	87.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	415,205,500.00	390,911,118.36	24,294,381.64	94.15
210101	Үндсэн цалин	257,525,100.00	253,742,092.32	3,783,007.68	98.53
210102	Нэмэгдэл	100,279,700.00	91,545,393.29	8,734,306.71	91.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,080,000.00	12,770,145.62	1,309,854.38	90.70
210104	Урамшуулал	43,320,700.00	32,853,487.13	10,467,212.87	75.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,052,700.00	51,486,613.43	4,566,086.57	91.85
210201	Тэтгэврийн даатгал	39,444,400.00	36,542,401.56	2,901,998.44	92.64
210202	Тэтгэмжийн даатгал	4,152,000.00	3,884,002.66	267,997.34	93.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,321,600.00	3,106,609.49	214,990.51	93.53
210204	Ажилгүйдлийн даатгал	830,400.00	768,043.68	62,356.32	92.49
210205	Эрүүл мэндийн даатгал	8,304,300.00	7,185,556.04	1,118,743.96	86.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,308,300.00	61,972,122.00	9,336,178.00	86.91
210301	Гэрэл, цахилгаан	10,250,000.00	3,263,822.00	6,986,178.00	31.84
210302	Түлш, халаалт	58,708,300.00	58,708,300.00	00.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,350,000.00	00.00	2,350,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,074,300.00	3,044,300.00	30,000.00	99.02
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	170,000.00	30,000.00	85.00
210404	Ном, хэвлэл	84,300.00	84,300.00	00.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	2,190,000.00	00.00	100.00
2105	Нормативт зардал	57,718,300.00	18,630,595.00	39,087,705.00	32.28
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,300.00	70,000.00	300.00	99.57
210502	Хоол, хүнс	56,148,000.00	17,060,595.00	39,087,405.00	30.39
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	00.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	132,500.00	132,500.00	00.00	100.00
210702	Дотоод албан томилолт	132,500.00	132,500.00	00.00	100.00

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5044000.00	5044000.00	00.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,172,000.00	3,172,000.00	00.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,872,000.00	1,872,000.00	00.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	609,035,600.00	531,721,248.79	77,314,351.21	87.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	537,227,300.00	469,249,126.79	67,978,173.21	87.35
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	537,227,300.00	469,249,126.79	67,978,173.21	87.35
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	71,808,300.00	62,472,122.00	9,336,178.00	87.00
132001	Орон нутгийн төсвөөс	71,808,300.00	62,472,122.00	9,336,178.00	87.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	32.00	32.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00	00.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,607,700.00	17,607,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,607,700.00	17,607,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,607,700.00	17,607,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,607,700.00	17,607,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,554,600.00	12,554,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,953,100.00	4,953,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,607,700.00	17,607,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,607,700.00	17,607,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00	100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,507,700.00	17,507,700.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахыг эрхэм зорилгоо болгон анхан шатны боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг юм.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын баг нь 2021 онд дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөө батлан, дотоод хяналтын ажлаа улирал бүр тайлагнан ажилласан.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба

хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 609,035.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,135.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,851.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 609,035.6 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 17,607.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 626,643.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 700.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 642.3 мянган төгрөгийн ном, нийт 2,142.3 мянган төгрөгийн хөрөнгийн

орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр худалдан авсан 792.3 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,350.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Бараа материалын дансанд хандиваар 19,956.9 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 22,818.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 20,040.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 69,160.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,156,405.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	-	-	-
Урьдчилгаа			-
Бараа материал	46,425.3	69,160.5	22,735.3
Үндсэн хөрөнгө	1,207,428.1	1,156,405.0	(51,023.1)
Нийт хөрөнгө	1,253,853.4	1,225,565.6	(28,287.8)
Өр төлбөр			
	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,253,853.4	1,225,565.6	(28,287.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,253,853.4	1,225,565.6	(28,287.8)

Бараа материалын дансны үлдэгдэл 69,160.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 22,735.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,156,405.0 мянган төгрөг болж 51,023.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,225,565.6 мянган төгрөг болж 28,287.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 609,035.6 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 609,035.6 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 609,035.6 мянган төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 537,227.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 71,808.3 мянган төгрөгийн, нийт 609,035.6 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 531,721.2 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 77,314.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 531,721.2 мянган төгрөг буюу 87.3 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 17,607.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгалд шилжүүлэгт 17,607.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 700.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 642.3 мянган төгрөгийн ном, нийт 2,142.3 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр худалдан авсан 792.3 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,350.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

3.8 Аудитын гол асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 75 нэр төрлийн 46,872.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 11 нэр төрлийн 3,341.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тус тус бүртгэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 176 мэдээлэл мэдээлэхээс 175 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 51,440.3 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 1,226.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 50,214.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 1,226.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Эрхлэгчийн 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Б/35 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулсан 1 албан хаагчид 1 сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн 886.4 мянган төгрөгөөр шагнаж цалингийн сангаас тооцон олгосон нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 1.7-д "Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй" гэсэн заалтыг зөрчсөн, мөн журмын 3.3-д "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацаанд Үндсэн ажлаас гадуур давхар хөдөлмөр эрхэлдэг 1 албан хаагчид ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсоны улмаас нийт 240.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгасан нь: ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн дутуу суутгасан ХХОАТ-ыг албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тайлант хугацаанд байгууллагын удирдлагын тушаал шийдвэргүйгээр 1 албан хаагчдад 99.9 мянган төгрөгийн Ур чадварын нэмэгдэл цалин тооцон олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон нэмэгдэл цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 75 нэр төрлийн 46,872.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 11 нэр төрлийн 3,341.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоолын 1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн анги доторхи зүйлийг НББОУС-д нийцүүлэн зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар залруулан бүртгэхийг дарга, захирал нарт даалгасугай", УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 176 мэдээлэл мэдээлэхээс 175 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэг	6	51,440.3	-	-	3	1,226.3	-	-	3	50,214.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn